

**БАЯЛАГ СҮМБЭР ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ПРОТОКОЛ**

ХУРАЛ БОЛСОН ГАЗАР: Хан-Уул дүүрэг, 15 хороо, Мандал хотхон, 42-11 тоот

ХУРАЛ ҮРГЭЛЖИЛСЭН ХУГАЦАА:10:00-12:00

ХУРАЛД ОРОЛЦСОН:

Хөхөө Агротех ХХК-ийг төлөөлж үүсгэн байгуулагч Хе ЖИНВЕН / 86.9%-64,611

ширхэг хувьцаа эзэмшигч /

Цэгмид овогтой ОЮУНТУЯА /5.0% - 3,608 ширхэг хувьцаа эзэмшигч /

Хе ШАНЬЖУН /5.0% - 3,608 ширхэг хувьцаа эзэмшигч /

ХУРАЛ УДИРДСАН:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дарга:Болд овогтой ОТГОНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Туз-ийн нарийн бичгийн дарга: Төмөрбаатар овогтой БАЯРМАА

ХУРАЛД БАЙЛЦСАН:

ТУЗ-ийн гишүүн : Пүрвээ овогтой ОЧИРХУЯГ

ТУЗ-ийн хараат бус гишүүн : КУ ЧЕНЬ ЧУАНЬ

ТООЛЛОГЫН КОМИСС:

Дарга: Батдэлгэр овогтой БАТЦЭЦЭГ

Гишүүн: Энхбат овогтой АНХБАТ

2019 ОНЫ 07 САРЫН 01

“БАЯЛАГ СҮМБЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

БУС ХУРЛЫН ПРОТОКОЛ

2019 оны 07 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 07 дугаар сарын 01 -нд 15 хороо, Мандал хотхон, 42-11 тоотод 10:00 цагт эхлэв.

Тооллогын комиссын дарга Б. Батцэцэг хурлын ирцийг бүртгэж, нийт 3 хувьцаа эзэмшигч ирсэн нь нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.6 хувийн ирцийг бүрдүүлж байгааг мэдэгдлээ.

Хурлын дарга Отгонбаатар хурлыг нээж хуралд оролцогчидод мэнд дэвшүүлэн хурлын дэгийг танилцуулав.

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Компанийн оноосон нэрийг өөрчлөх талаар хурлын дарга Б. Отгонбаатар:

- Компанийн оноосон нэрийг Глобал лайф технологи гэж өөрчлөхөд Улсын бүртгэлийн зүгээс аливаа давхцал байхгүйг олж мэдсэн. Тиймээс хурлын шийдвэр гармагц энэ асуудлыг даруй хөөцөлдье.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т. Баярмаа:

- Юуны түрүүнд хурлын материал, шийдвэрүүдийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид өгч манай хурлыг хүчин төгөлдөрт тооцсоны дараа УБЕГ-т хандах дүрэмтэй.

Ингээд компанийн оноосон нэрийг өөрчлөх асуудалыг бүгд дэмжлээ.

Дараагийн асуудал болох Дүрэмд өөрчлөлт оруулах саналуудыг хэлэлцэж эхлэв.

- ❖ Компанийн дүрэм 1.3-т Компанийн оноосон нэрийн холбогдох өөрчлөлтийг оруулахыг бүгд дэмжив.
- ❖ Компанийн дүрэм 1.4-т Компанийн оноосон нэрийн холбогдох өөрчлөлтийг оруулахыг бүгд дэмжив.
- ❖ Компанийн дүрэм 1.5-т Компанийн хаягийн холбогдох өөрчлөлтийг оруулахыг бүгд дэмжив.
- ❖ Компанийн гэрчилгээ дээрх Улаан буудай, төмс хүнсний ногоо тариалах, байгалийн хадлан бэлтгэх; Өөрийн нэрийн бүтээгдэхүүний дэлгүүр; Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх гэсэн үйл ажиллагааны чиглэлүүдийг Дүрмийн 2.3.2; 2.3.3; 2.3.4-т оруулаж, цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх тул нэмэлтээр 2.3.5 Бизнесийн зөвлөгөө өгөх; 2.3.6 Худалдааны зуучлал; 2.3.7 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа; 2.3.8 Мал эмнэлгийн үйл ажиллагаа; 2.3.9 Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн чиглэлүүдийг оруулахыг бүгд дэмжив.

- ❖ Хувьцаа эзэмшигчдийн дунд гадаад улсын иргэд байдаг тул тэдний хуралд оролцох боломжийг хангаж цахим хэлбэрээр хуралд оролцож болно гэж дүрэмд зааж өгөх нь зүйтэй гэж үзэн Дүрмийн 7.2 –т “Хуралд хувьцаа эзэмшигчид биечлэн болон цахим хэлбэрээр оролцож болно. Цахим хэлбэрээр гэдгийг “we chat video call” гэж ойлгоно.” гэж нэмэхийг бүгд дэмжив.
- ❖ 7.64 дэх хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын хэмжээг цалин урамшууллын хорооны санал, шийдвэрийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно” гэж оруулж 7.6.15 дах хэсгийн “ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах” хэсгийг хасахыг бүгд дэмжлээ.
- ❖ 7.36 дах хэсгийг “Төлөөлөн удирдах зөвлөл/ТУЗ/ нь энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэсэн заалт өгүүлбэрийн найруулга зүй алдагдсан төдийгүй тодорхой утга илэрхийлэхгүй байгаа тул “Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дүгээр хэсэгт зааснаас бусад асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх бүрэн эрхтэй болно” гэж шинэчлэн найруулав.
- ❖ 7.39 дэх заалтын эхний өгүүлбэр “ТУЗ-ийн хараат гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 3 жилийн хугацаатай, хараат бус гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 1 жилийн хугацаагаар сонгоно.” гэж байгааг тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс ердийн болон хараат бус гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 жилийн хугацаагаар сонгох тухай оруулахыг хувьцаа эзэмшигчдийн зүгээс дэмжив.
 - Хэдий хугацааг 3 жилээр томилж байгаа ч жил бүрийн 4 сарын 30 ны дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулахгүй бол хуулийн дагуу ТУЗ эрх мэдэлгүй болж түүний шийдвэрүүд хүчин төгөлдөр байж чадахгүйд хүрдэг шүү гэдгийг ТУЗ-ийн нарийн бичиг сануулав.
 - Хурлын дарга Б. Отгонбаатар ээлжит хурал болон холбогдох хугацаат ажлуудыг ТУЗ-н гишүүдэд сануулж байхыг нарийн бичгийн дарга Т. Баярмаагаас хүсэв.
- ❖ 7.44 дэх заалтад “ТУЗ нь 11 гишүүнтэй байна гэж заасныг 9 болгон өөрчлөхийг бүгд дэмжлээ.
- ❖ 7.65 дах заалтад “Гүйцэтгэх захирал нь өөр компани аж ахуйн нэгжийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж болно. Харин өөр компани аж ахуйн нэгжийн гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно” гэхийг өөр компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж болно гэж хувьцаа эзэмшигчид санал нэгдлээ.
- ❖ 8.1 дэх заалтын эхний өгүүлбэрт “ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Дэд захирал, Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий инженер, Ерөнхий менежер, Үйлдвэр цех, албадын дарга зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно” гэсэн хэсгийг Компанийн тухай хуулийн 84.1; 84.2 дах хэсэгт нийцүүлэн “8.1 Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирал санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ерөнхий менежер, ерөнхий инженер,

үйлдвэр цех, албадын дарга төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.” гэж шинэчлэн найруулахыг хувьцаа эзэмшигчид дэмжив.

- ❖ Дүрмийн 7.34-7.35 гэсэн заалтууд давхцаж 2 удаа дугаарлагдсан байгааг 7.35 – 7.69 хүртэл зөвхөн дугаарлалтын дарааллыг засахыг дэмжлээ.

Ийнхүү хувьцаа эзэмшигчид компанийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэж дуусаад хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Хурлын дарга Б. Отгонбаатар танилцууллаа.

Хурлын дарга нэмэлт асуулт байгаа эсэхийг лавлав. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн зүгээс нэмэлт асуулт байсангүй.

Тооллогын комиссын дарга санал хураалтыг эхлүүлэхээс өмнө саналын хуудсыг хэрхэн зөв бөглөх талаар тайлбар хэлээд саналын хуудсыг тараагаад бөглөгдсөний дараа хураан авав.

Хурал 20 минут завсарлав.

Завсарлах хооронд тооллогын комисс саналын хуудсыг нягтлав.

Завсарлага дуусч Тооллогын комисс санал хураалтын дүнг дараах байдлаар танилцуулав.

- Хуралд нийт 3 хувьцаа эзэмшигч оролцсоноос санал өгсөн-3, үүнээс хүчингүй саналын хуудас-0, нийт 3 саналын хуудсыг хүчинтэйд тооцлоо. Хувьцааны эзлэх хувиар тоолж үзэхэд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцсэн асуудалууд 99.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хурлын дарга Б. Отгонбаатар санал хураалтын дүнгээс үндэслэн гарсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Хурал дэгийн дагуу амжилттай явагдглаа.

Хурлын дарга Б. Отгонбаатар Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлэн, хурлыг хаасныг мэдэгдлээ.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ҮНЭН ЗӨВИЙГ БАТАЛСАН:

2019 ОНЫ 7 САРЫН 1 НИЙ ӨДРИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА:



/Б.ОТГОНБААТАР /